

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ”-Д ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДУА-2023/19-10-ШТА-ГА

Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох
Утас: 70592439,
Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор Т.Батсайхан
Аудитор Л.Уранбилэг
Аудитор Г.Самданцоодол
Утас: 70593208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Аудитын тайланг баталгаажуулах тухай	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгс	5
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	6-9
	Дүрслэлийн товчг	10
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>Бүлэг 1. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдахгүй байна.</u>	11
Аудитын менежер Х.Наранцаирал	<u>4.1</u> Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжээгүй байна.	11
Ахлах аудитор Т.Батсайхан	А.1.1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилт, арга хэмжээний уялдаа холбоо муу, хэрэгжилт хангалтгүй байна.	11
Аудитор Л.Уранбилэг	А.1.3. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал бий болж байна	12-13
Г.Самданцоодол	<u>Бүлэг Б.1. Орон нутагт эрүүл мэндийн байгууллагууд даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжгүй байна.</u>	13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	<u>Б.1 Аймагт зарлагын төлөвлөлт хийгддэггүй, орлогын төлөвлөлт хийгддэг ч үндэслэлтэй төлөвлөдөггүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзүүлэгч байгууллагуудад зарлагын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгохгүй байна.</u>	13
	Б.1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй батлуулж, орлогыг бүрэн төвлөрүүлэхгүй байна.	13-15
ХАЯГ:	Б.1.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг тайлагнадаг ч санхүүжилтийн хасагдал өндөр байна.	15-17
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот	Б.1.3 Аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс ЭМДЕГ-аас батлагдсан орон тоогоор ажиллаагүйгээс хэрэгжүүлбэл зохих зарим чиг үүргүүд хэрэгжихгүй байна.	17-18
2023 оны 5 дугаар сар	Б.1.4 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн	

байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг батлагдсан журмын дагуу зохион байгуулж байгаа ч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахгүй, гэрээний нөхцөл, хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулдаггүй байна.	18-19
Б.1.5 Эрүүл мэндийн даатгалын гэрээг хугацаанд нь дүгнэдэггүй, гэрээний эрх, үүргүүд хангагдахгүй байна.	19-20
Б.1.6 Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд үзүүлсэн тусламж үйлчилгээний төлбөрөө бүрэн авч чадахгүй байна	20-21
<u>Бүлэг Б.2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд тодорхой ахиц дэвшил гаргаагүй байна.</u>	21
Б.2.1.Эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажиллаагүй.	21-21
Б.2.2 Цахим мэдээллийн систем найдвартай байдлыг хангаж чадахгүй байна.	22-22
Б.2.3 Эрүүл мэндийн даатгалын байгууллага иргэд, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	22-23
<u>Бүлэг Б.3. Хууль тогтоомжид заасан хяналт тавих чиг үүрэг бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт, шинжилгээ үнэлгээ бодитой бус байна.</u>	23
Б.3.1. Хяналт, шинжилгээ үнэлгээ бодитой бус байна.	23-24
Б.3.2. Үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд хийсэн хяналтаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийгээгүй, эргэх холбоо тогтоох чиг үүрэг хангалтгүй байна.	24-25
<i>Дүгнэлт</i>	25-26
<i>Зөвлөмж</i>	27-28
<i>Санал</i>	29-31
<i>Шалгагдагч байгууллагын санал, тайлбар</i>	32-34
<i>Хавсралт</i>	35-42



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 1/10.

Мандалговь

**Аудитын тайланг
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан / ДУА-2023/19-10-ШТА-ГА / -г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага)-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн, Засаг дарга /Ц.Мөнхбат/, аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга /С.Долгорсүрэн/, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Г.Батжаргал, Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Алтантөгс /нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2023 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын гуравдугаар нэгжийн ахлах аудитор /Т.Батсайхан/ аудитор /Л.Уранбилэг/, /Г.Самданцоодол/ нарт үүрэг болгосугай.

Р.МӨНХТОГТОХ

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
ААНБ	Аж ахуй нэгж, байгууллага
ГА	Гүйцэтгэлийн аудит
ДУА	Дундговь аймаг
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МЭИК	Монгол эм импекс концерн
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СЭМТ	Сумын эрүүл мэндийн төв
ТҮ	Тусламж үйлчилгээ
УАУНЭ	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг
УИХ	Улсын их хурал
УСЭИОШ	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоо шинжилгээ
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШТА	Шууд тайлагнах аудит
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭЭС	Эм эргэлтийн сан

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоол, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.

Аудитын зорилго, зорилт:

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх;
- Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх;

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль, эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль (2022 он);
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996 он);
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005 он);

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2015 он);
- Шилэн дансны тухай хууль (2014 он);
- Эрүүл мэндийн тухай хууль (2011 он);
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015 он);
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль (2015 он);
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (2016 он);
- "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол);
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай (УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол);
- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин" (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол);
- Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030 он)
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2020-2023 оны тогтоолууд;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2020-2023 оны тушаалууд;
- Дундговь аймгийн стратеги төлөвлөгөө (2021-2025 он)
- Дундговь аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020-2025 он)
- Дундговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (2021-2024 он)
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, өрх,

<i>Аудитын арга зүй:</i> <i>Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа</i> <i>Аудитын дүн</i>	сумын Эрүүл мэндийн төвүүд, Нийгмийн даатгалын хэлтэс болон бусад холбогдох байгууллагуудын 2021-2022 оны үйл ажиллагааг хамрууллаа. Шүүхийн шийдвэртэй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлыг аудитад хамруулахгүй болно. Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүллээ. Аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулсан. Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, аудитын 2-р нэгжийн ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Л.Уранбилэг, Г.Самданцоодол нар 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд аудитыг гүйцэтгэлээ. Аудитаар нийт аймгийн Засаг даргад 4, Эрүүл мэндийн газарт 2, Нийгмийн даатгалын хэлтэст 1, Эрүүл мэндийн даатгалын хэлтэст 3 нийт 10 заалт бүхий зөвлөмж тус тус хүргүүлээ.
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	УИХ-аас Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр эрүүл мэндийн даатгалын хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэж, иргэд эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдах, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн тариф, шалгуурыг оновчтой болгох ажлууд хэрэгжиж эхэлсэн байна. Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн тусламж,

үйлчилгээний санхүүжилтийг олон улсын эмнэл зүйн удирдамжид үндэслэн оношны хамааралтай бүлгээр нэхэмжлэх эмчилгээ, үйлчилгээний тарифыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2021 оны 03 болон 04 дүгээр тогтоолоор баталсан байна.

Монгол Улсад эрүүл мэндийн дараах тусламж, үйлчилгээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;
- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ;
- Эх барихын тусламж, үйлчилгээ;
- Яаралтай тусламж үйлчилгээ;
- Түргэн тусламжийн үйлчилгээ;
- Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;
- Сэргээн засах тусламж, үйлчилгээ.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, гүйцэтгэлээр санхүүжилт олгосноор Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал 2022 онд өмнөх 2 жилтэй харьцуулахад 2.0-4.4 дахин нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоо 2022 онд 2020 оноос 9.1 хувиар өссөн бол 2021 оноос 1.2 хувиар буурсан байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц нь даатгуулагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн тусламж, үйлчилгээг бүрэн хамардаггүй тул нэр заасан тусламж, үйлчилгээнд нь багтаагүй тохиолдолд даатгуулагч хувиасаа төлбөр төлдөг байна.

Мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, улсын эмнэлгүүдийн ачаалал, дараалал ихээс шалтгаалан хэрэгцээт үйлчилгээгээ авч чадахгүй, даатгалаар үйлчилдэггүй хувийн эмнэлгүүдээс төлбөртэй үйлчилгээ авах сонголттой тулгардаг байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг зарим байгууллага оношны бүлгийг буруу нэхэмжилсэн, яаралтай тусламжийн эрэмбэ буурсан, эрүүл мэндийн байгууллагаас хэвтүүлэн эмчлэх үйлчилгээний төлбөрийг давхардуулан авсан, эмчийн онош зөрсөн, хэвтэн эмчлүүлсэн нэхэмжлэлийн огноо зөрүүтэй, эрүүл мэндийн цахим мэдээллийн системийн программын хөгжүүлэлт удааширсан зэрэг шалтгаанаар эрүүл мэндийн зарим байгууллага эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээ бүрэн авч чадахгүй хүндрэлүүд аймгийн хэмжээнд гардаг байна.

График, дүрслэл товъёг


№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Хамрагдалтын хувь	28

Хүснэгтийн товъёг

№2	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ЭМС-тай болон ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний хэрэгжилт	12
Хүснэгт 2	Тусламж үйлчилгээний санхүүжилт	15
Хүснэгт 3	ЗД-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт	16

Хавсралтын товъёг


№3	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Эрүүл мэндийн даатгалын хамрагдалт, орлогын төлөвлөгөөний биелэлт	33
Хавсралт 2	Сумын эрүүл мэндийн төвүүдийн 2021 онд ЭМДС-гаас хүлээн авсан нийт санхүүжилт	34-36
Хавсралт 3	Эрүүл мэндийн салбарын ажилчдын хүний нөөцийн судалгаа	37-38
Хавсралт 4	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээ дүгнэсэн байдал	39-39
Хавсралт 5	Эмийн сангуудын гэрээ гэрээ дүгнэсэн байдал	40-40



Бүлэг 1. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдахгүй байна.

A1. Монгол Улсын хөгжлийн бодлогын үрт, дүнд болон богино хугацааны баримт бичигт эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжээгүй байна.

A.1.1 Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилт, арга хэмжээний уялдаа холбоо муу, хэрэгжилт хангалтгүй байна.



Эрүүл мэндийн даатгал

Засаг даргын Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээнд эрүүл мэндийн даатгалтай холбоотой 1 заалт тусгасан бол, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээнд эрүүл мэндийн даатгалтай холбоотой 4 заалтыг тус тус тусгаж төлөвлөсөн байна.

Эрүүл мэндийн сайдтай байгуулсан 2021, 2022 оны гэрээнд эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой төлөвлөсөн арга хэмжээнээс Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021, 2022 оны жилийн төлөвлөгөөнд 5 заалт тусгагдсан байна. Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээнд “Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу эмзэг бүлгийн иргэдийг бүрэн хамруулах, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллах, эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааг тогтмол хийж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлж ажиллана” гэсэн заалт тусгасан боловч эдгээр ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй, байгууллагууд хоорондын уялдаа холбоо муу, аймгийн бодлогын баримт бичигт тусгаагүй байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 2021, 2022 онд байгуулсан гэрээнд эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой тусгасан заалтуудаас Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021, 2022 оны жилийн төлөвлөгөөнд 1 заалтыг тусгаж, 4 заалт тусгаадаагүй бол 2022 онд гэрээнд 1 заалтыг тусгаж, 3 заалт тусгаагүй байна.

/Хүснэгт 1/

Гэрээний нэр	2021		2022	
	Эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой заалт	Хэрэгжилтийн хувь	Эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой заалт	Хэрэгжилтийн хувь
ЭМС-тай байгуулсан гэрээ	1	90	1	65
ЭМДЕГ-тай байгуулсан гэрээ	4	76	4	100

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан арга хэмжээний жил бүрийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, эрүүл мэндийн даатгалын үндсэн гол үзүүлэлтүүд болох эрүүл мэндийн даатгалын хамрагдалтын түвшин, малчин, ажилгүй иргэн, оюутан суралцагчдын тоо зэрэгт дүн шинжилгээ хийж, суурь судалгаа, тооцоонд үндэслэн боловсруулаагүй байна.

Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас жил бүр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулж, тусламж үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, төлбөрийн хэмжээг тусгадаг боловч Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд нь хоорондоо харилцан ойлголцохгүй байгаагаас 2022 оны гэрээг дүгнээгүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай 2023 оны гэрээг байгуулаагүй байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жил бүрийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, дүн шинжилгээ хийгээгүй, тоо мэдээлэл, тооцоо судалгаа нь зөрүүтэй байна.

Энэ нь эрүүл мэндийн даатгалын ажил хариуцсан албан тушаалтан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муу, урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслээгүй, жил бүр хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаагүйтэй холбоотой байна.

A.1.3 Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал бий болж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр болжээ.

Эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлсний үр дүнд эмч, ажилчдын цалинг нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой урсгал засвар үйлчилгээг хийх асуудлыг төсвийн шууд захирагчийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд үзүүлэх боломжтой тусламж үйлчилгээг лавлагаа шатлалын эрүүл мэндийн төвүүдэд үзүүлэхээр, лавлагаа шатлалаас авах тусламж, үйлчилгээг дараагийн шатлалын тусламж үйлчилгээг авахаар зохицуулж өгсөн нь нэг талаас дээрх байгууллагууд санхүүжилт бүрэн авч чаддаггүй, нөгөө талаас иргэд анхан шатны тусламж үйлчилгээг авч чадахгүй байгаа нь иргэдэд чирэгдэл учруулж байна.

Мөн яаралтай тусламжийн эрэмбийг хязгаарласан, оношийн хамааралтай бүлэгт холбогдолгүй, эмч боловсон хүчний дутагдал, хүн ам цөөтэй хөдөө орон нутаг, алслагдсан байдал зэргээс шалтгаалан Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

Эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатлалын эрэмбийн хязгаарыг орон нутгийн нөхцөл байдалд тохируулан бууруулж, орон нутгийн иргэд шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг оршин суугаа газраасаа чирэгдэлгүй авах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Ингэснээр анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт өсөж, тусламж үйлчилгээний цар хүрээ өргөжин, тухайн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангагдаж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж сайжрах боломжтой байна.



Бүлэг 2. Орон нутагт эрүүл мэндийн байгууллагууд даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжгүй байна.

Б.1 Аймагт зарлагын төлөвлөлт хийгддэггүй, орлогын төлөвлөлт хийгддэг ч үндэслэлтэй төлөвлөдөггүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзүүлэгч байгууллагуудад зарлагын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгохгүй байна.

Б.1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй батлуулж, орлогыг бүрэн төвлөрүүлэхгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл, ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл, төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл зэрэг 3 эх үүсвэрээс бүрддэг байна.



Төрөөс хариуцах иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс бусад 2 эх үүсвэрийн сангийн орлого бүрдүүлэлтийг 2020-2022 оны байдлаар авч үзэхэд төвлөрүүлсэн нийт орлого 2,589.5–3,211.5 сая төгрөг байгаагийн 89.2-90.5 хувийг төсөвт болон аж ахуй нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчдаас, 1.7-2.2 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнээс, 7.0-7.7 хувийг малчдаас, 0.65-0.93 хувийг оюутан суралцагчдаас тус тус бүрдүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан нийт иргэд 41,821-42,531 байгаагийн 34,008-31,394 иргэн буюу 73.8 -81.3 хувь нь төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэд буюу 0–18 насны хүүхэд, тэтгэврийн насны иргэд, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай иргэн, хүүхдээ асарч буй эх/эцэг, хугацаат цэргийн албан хаагчдаас бүрдэж байгаа бол үлдэх 18.7- 26.2 хувийг төсөвт болон аж ахуй нэгж, байгууллагын ажилтан албан хаагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, оюутан суралцагч эзэлж байна. (Дэлгэрэнгүйг Хүснэгт 1-ээс харна уу.)

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэлтийг сумдад Нийгмийн даатгалын байцаагч нар хариуцдаг. Жил бүр эрүүл мэндийн даатгалын орлогын төлөвлөгөөг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас баталж Нийгмийн даатгалын ерөнхий газраар дамжуулан аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст ирүүлдэг. Орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй буюу хамруулбал зохих, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, оюутан суралцагчийн тоотой харьцуулахад 40-50 хувийг хамруулахаар төлөвлөсөн байна.


Мөн 2022 онд малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах төлөвлөлтийг хийхдээ 2020, 2021 оноос 10-21 хүртэл хувиар бууруулж төлөвлөсөн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг сүүлийн 3 жилийн дүнгээр авч үзвэл хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хувьд 27.3-44.5 хувьтай, малчид 36.5-50.1 хувьтай, оюутан суралцагчид 26.9-62.1 хувьтай биелүүлсэн нь эрүүл мэндийн даатгалд иргэдийг хамруулах ажил хангалтгүй, орлогын төлөвлөгөө тасарч, орлого бүрэн төвлөрөхгүй байна. Нийгмийн даатгалын байцаагч нар иргэдийг И-баримтын системээр нэвтэрч даатгалаа төлөхийг зөвлөж төлүүлдэг ч сумын төрийн сангийн дансанд ордоггүй тул сумын мэдээнд ордоггүй, Нийгмийн даатгалын хэлтсээс сумдаар нь гаргаж өгдөггүйгээс орлогын гүйцэтгэлийг тооцох боломжгүйд хүргэж байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумын Засаг дарга нар төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан суралцагчийн эрүүл мэндийн даатгалд хамралтыг 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2021 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний хамралт 38.7 хувиар, малчны хамралт 21.1 хувь, оюутан суралцагчийн хамралт 52.5 хувиар буурсан байна.

Мөн 2022 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний хамралт 34.0 хувиар, малчны хамралт 14.5 хувь, оюутан суралцагчийн хамралт 45.8 хувиар тус тус буурсан буюу 2020 онд дээрх төрөл тус бүр дээр төлөвлөгөө 44.5-62.1 хувьтай биелж байсан тус дүнгээс сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол буурсан үзүүлэлттэй байна./Хавсралт№1/

График№1/



Эрүүл мэндийн сангийн орлогын төлөвлөгөөний хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, оюутан суралцагчийн хамрагдалтын төлөвлөгөө сүүлийн 3 жилийн дүнгээр 28.5-61.4 хувиар тасарч 723.5 сая төгрөгийн төвлөрүүлээгүй байна. Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлээгүй байна. Орлого төлөвлөлтийг бодитой хийж, бүрэн хамруулахгүй байгаа нь иргэн гэнэтийн болон урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдах шаардлага үүсэхэд эрүүл мэндийн даатгалаа төлөөгүйгээс эрүүл мэндийн тусламж авахад хугацаа алдах, тусламж үйлчилгээ авч чадахгүй эрсдэл үүсэж байна. Мөн эрүүл мэндийн байгууллага зайлшгүй тохиолдолд эрүүл мэндийн даатгалгүй иргэнд тусламж үйлчилгээ

үзүүлдэг бөгөөд үзүүлсэн үйлчилгээнийхээ санхүүжилтийг авч чадахгүй санхүүгийн алдагдал хүлээх сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Эрүүл мэндийн даатгалын орлого хураах, төвлөрүүлэх ажлыг хариуцсан Нийгмийн даатгалын хэлтэс нь сумдын байцаагч нарт 2020-2021 оны хамрагдалтын төлөвлөгөөг хуваарилж хүргүүлээгүй, мэдээлэл судалгаа хангалтгүй, төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.

Иймд сумдын нийгмийн даатгалын байцаагч нарт эрүүл мэндийн даатгалын орлогын төлөвлөгөөг бодитойгоор хуваарилан өгөх, төлөвлөгөөний гүйцэтгэлд сар бүр хяналт тавьж, И-баримтын системээр төлөгдөж байгаа эрүүл мэндийн даатгалын орлогыг сумаар ялган харагдах, орон нутаг дахь дансандаа төвлөрдөг байх боломжийг судалж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Б.1.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг тайлагнадаг ч санхүүжилтийн хасагдал өндөр байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд болох аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Мөнхдэлгэр, Элбэрэл буян хувийн эмнэлгүүдтэй Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгээс сонгон шалгаруулалтаар гэрээ байгуулсан байна.



Харин Эрүүл мэндийн даатгалын хэлтэс 15 сумын Эрүүл мэндийн төв, Сайнцагаан сумын Өлзийт мандал, Боржигон мандал өрхийн эрүүл мэндийн төвүүд болон 14 сумын Эм эргэлтийн сангууд, хувийн хэвшлийн 10 Эмийн сан, нийт 41 байгууллагатай гэрээ байгуулан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн санхүүжилтийн нэхэмжлэлийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 07 болон 12 дугаар тогтоолоор батлагдсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ын дагуу хянаж шийдвэрлэж ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт сар, улирал, жилээр мэдээ тайланг батлагдсан маягт хавсралтын дагуу гаргаж байна. Үүнд: Эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн нэгтгэл, тооцоо нийлсэн актын бүртгэл, олгосон тусламж үйлчилгээний зардлын тайлан, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын тайланг тусламж үйлчилгээний төрөл тус бүрээр гаргадаг байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021, 2022 оны гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудад олгосон тусламж, үйлчилгээний зардлыг төрөл, байгууллага тус бүрээр хавсралт 2 -оос танилцана уу. /Хавсралт 2- /

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 2021 онд нийт 183,643 тусламж үйлчилгээ үзүүлж 14,169.0 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс 20,703 тусламж үйлчилгээний 2,036.6 сая төгрөгийн санхүүжилтийг цахим хяналт, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн эмч, байцаагчийн хяналтаар хасаж, 168,603 тусламж үйлчилгээний 12,132.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Хяналтаар хасагдсан 20,703 тусламж үйлчилгээ нь нийт тусламж үйлчилгээний 11.3 хувийг, хасагдсан санхүүжилтийн дүн 2,036.6 сая төгрөг нь нийт нэхэмжилсэн санхүүжилтийн 14.4 хувийг тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд 2022 онд нэг иргэнд ногдох санхүүжилт 6,205.4 сая төгрөгийг хяналтгүй шууд олгосон бол 149,001 тусламж үйлчилгээ үзүүлж 10,213.8 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс 4,220 тусламж үйлчилгээний 554.3 сая төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс хяналтаар, 512.7 сая төгрөгийн санхүүжилтийг цахим хасалтаар хасаж 143,263 тусламж үйлчилгээний 9,146.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож шийдвэрлэсэн байна. Хяналтаар хасагдсан 4,220 тусламж үйлчилгээ нь нийт тусламж үйлчилгээний 2.8 хувийг, мөн хасагдсан санхүүжилтийн дүн болох 1,067.0 сая төгрөг нь нийт нэхэмжилсэн санхүүжилтийн 10.4 хувийг тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт хасагдаж байгаа шалтгааныг дараах байдлаар 4 ангилж үзэхээр байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанаас шалтгаалах /хүний нөөц, ажлын зохион байгуулалт, гэрээ, дүрэм журам г.м/;

2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын батлан гаргасан тогтоол, шийдвэрүүд орон нутгийн бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байх, ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.4-д уян хатан байх, өөрчлөлттэй уялдах зарчмыг баримтлахаар зохицуулсан ч хэрэгжихгүй;

3. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь бүрэн бүтэц орон тоогоор ажиллаагүйгээс зарим үндсэн чиг үүргийг хэрэгжүүлээгүй;

4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хэрэглэж байгаа программ хангамжийн хөгжүүлэлт хангалтгүй, гацалт ихтэй, сургалт дадлага хийлгүйгээр нэвтрүүлсэн.



Сумдын Эрүүл мэндийн төвүүд үзүүлсэн тусламж үйлчилгээний төлбөрийн санхүүжилтээ нэхэмжлэхгүй байх тохиолдол цөөнгүй гардаг байна.

Тухайлбал: 2021 онд Дэлгэрцогт сумын ЭМТ 5 сар, Сайхан-Овоо сумын ЭМТ 4 сар, Дэрэн сумын ЭМТ 2 сар, Дэлгэрхангай сумын ЭМТ 5 сар, Сайнцагаан сумын Боржигон мандал ӨЭМТ 2 сар, 2022 онд Дэлгэрцогт сумын ЭМТ 11 сар, Сайхан-Овоо сумын ЭМТ 8 сар, Дэрэн сумын ЭМТ 3 сар, Хулд сумын ЭМТ 5 сарын хугацаанд тус тус сэргээн засах, гэрийн үйлчилгээ, өдрийн эмчилгээ, онош шинжилгээний тусламж үйлчилгээний ямар нэгэн төлбөрийн нэхэмжлэлийг огт илгээгүй байна.

Энэ нь программын сургалт хийгдээгүй, дүн бүртгэгч ажлаас гарсан, бодит цагийн горим хэрэгжээгүй, ковидын санхүүжилт өндөр авсан тул төсвийн хүндрэл гараагүй зэрэг тайлбар өгч байгаа нь тодорхой үндэслэлтэй ч ажлын хариуцлагагүй байдал, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс болон Эрүүл мэндийн газраас хяналт тавьдаггүй, шаардаж ажиллаагүйгээс шууд хамааралтай байна.

Бодит цагийн горим хэрэгжихгүй байгаа нь Дундговь аймгийн хэмжээнд 15 сумын эрүүл мэндийн төвд эмчийн 28 орон тоо дутуу ажиллаж, нэг эмчид ногдох ажлын ачаалал их, өдрийн эмчилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгч эмчилгээгээ дуусгадаггүйгээс шалтгаалсан байна. Энэ нь цалин хөлс, ажлын ачаалал, амьдрах орчин нийгмийн асуудлыг шийдвэрлэлт хангалтгүй шалтгаанаар ажлын байрнаас гарч уул уурхай, хувийн хэвшлийн болон дээд шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжин ажиллах нь жилээс жилд

нэмэгдэж байна. /Хавсралт №3-аас харна уу/ Аймгийн хэмжээнд нийт 57 эмч, эмнэлгийн ажилтан дутагдалтай байна. Орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрөөс 2021 онд 13 сувилагчтай гэрээ байгуулж 19.2 сая төгрөг, 2022 онд Их эмч -2, сувилагч-2 гэрээ байгуулж 12.8 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн байна. Үүнээс харахад их эмч бэлтгэх, суурьшуулж ажиллах талаар хангалттай ажил хэрэгжүүлээгүй байна.

Дээрх бодит цагийн горим хэрэгжээгүй, хэрэгжих боломж орон нутагт хомс байгаа нь 2022 онд анхан шатны ЭМТ-үүд ерөнхий мэргэжлийн яаралтай тусламж үйлчилгээний санхүүжилт 34.4 сая төгрөг нэхэмжилснээс 30.1 сая төгрөг буюу 87.5 хувь нь цахим хяналтаар хасагдаж, 12.5 хувь буюу 4.3 сая төгрөгийг олгосноос харж болохоор байна.

Хүснэгт №2

/сая төгрөгөөр/

	Тусламж үйлчилгээ	Цахимд илгээсэн		Эмчийн хасагдал		Цахим хасагдал	Олгосон санхүүжилт		Нийт хасагдлын хувь
		Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	
1	Хэвтэн эмчилгээ	279	106.2	39	11.3	32.75	-	62.2	41.4
2	Хэвтэн мэс засал	-	-	-	-	-	-	-	
3	Яаралтай ерөнхий мэргэжлийн	105	34.4	1	0.043	30.1	-	4.3	87.5
4	Яаралтай гэмтлийн	-	-	-	-	-	-	-	
5	Түргэн ойр	218	12.8	4	0.34	0	211	12.5	2.3
6	Түргэн алс	20	8.9	-	-	0,74	20	8.1	9.0
7	Амбулатори	-	-	-	-	-	-	-	
8	Уламжлалт	-	-	-	-	-	-	-	
	Дүн	622	162.3	44	11.7	63.6	575	87.1	46.3

Эх сурвалж: ЭМДХ-ийн мэдээ

Сумын ЭМТ-үүдийн хэвтэн эмчилгээний төлбөрийн 106.2 сая төгрөгийн нэхэмжлэлийн 30.7 хувь болох 32,8 сая төгрөг цахимаар, 10.6 хувь болох 11.3 сая төгрөг нь эмчийн хяналтаар хасагдсан нь бодит цагийн горим, оношийн бүлэгт хамааралгүй гэх алдаа нөлөөлсөн байна.

Жил бүрийн цэрэг татлагаар эрүүл мэндийн үзлэг зохион байгуулахад аймгийн нэгдсэн эмнэлгээс 14 хүний бүрэлдэхүүнтэй багийг 10 хоног гаргаж, цалинд 6.0 сая төгрөгийг байгууллагаас олгодог. Тус ажиллах хугацаанд байгууллагын алдагдаж байгаа боломжийг тооцож үзвэл амбулаторийн 1 эмч өдөрт 32 үзлэг хийдэг ажлын 10 хоногт 320 хүнээр 12 эмчээр тооцоход 65.3 сая төгрөг болдог бөгөөд ийм хэмжээний алдагдлыг жилд 2 удаа хүлээдэг байна.

Иймд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт төдийлөн үр нөлөөтэй бус системийн хэмжээний бодлого шийдвэр, дүрэм журамд өөрчлөлт шинэчлэлт хийх зайлшгүй шаардлагатай байгаа тул холбогдох байгууллагуудад санал, зөвлөмж хүргүүлээ. **Б.1.3 Аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас батлагдсан орон тоогоор ажиллаагүйгээс хэрэгжүүлбэл зохих зарим чиг үүргүүд хэрэгжихгүй байна.**



Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийн нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалтыг 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/10 тушаалаар шинэчлэн баталжээ. Дундговь аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2021 оноос 2 орон тоотой ажиллаж байна. ЭМДХ-нь төсөв хөрөнгө захиран зарцуулдаггүй Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас цалин холбогдох батлагдсан зардлуудыг хариуцан санхүүжилдэг.

ЭМДХ-ийн батлагдсан орон тоо 4 бөгөөд 2 орон тоо дутуу ажиллаж байгаагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чанарын үнэлгээ хийх, төлбөрийн хяналтаар өгөгдсөн зөвлөмжийн мөрөөр гүйцэтгэлийн хяналт хийх, эрүүл мэндийн даатгалын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянах, иргэд даатгуулагч нарт эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдээллээр хангах зэрэг чиг үүргүүд хэрэгжихгүй байна. Мөн эрүүл мэндийн даатгалын бодлого төлөвлөлт, эрүүл мэндийн анхан болон 2 дахь шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй байна.

Иймд Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь ЭМДЕГ-т дутуу орон тооны захиалгаа хүргүүлж, хүний нөөцөө бүрдүүлж, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээний хөтөлбөр боловсруулах, түүний хэрэгжилт, үр дүнг тооцох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, орлогын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан ажиллах шаардлагатай байна.

Б.1.4 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг батлагдсан журмын дагуу зохион байгуулж байгаа ч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахгүй, гэрээний нөхцөл, хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулдаггүй байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг зохион байгуулдаг. Сонгон шалгаруулалтыг 3 жилд нэг удаа зохион байгуулж, тус хугацаанд гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах зохицуулалт байхгүйгээс оношийн хамааралтай бүлгээр гэрээлж чадаагүй ч тусламж үйлчилгээг үзүүлэх шаардлага үүсдэг тул сонгон шалгаруулалтын хүсэлтийг шаардлага хангасан тухай бүрд хүлээн авч шийдвэрлэдэггүй байна.

Тухайлбал: Сэргээн засахын тусламж үйлчилгээ (350011¹, 350022², 350023³, 350019⁴, сэтгэцийн тусламж үйлчилгээ (200981⁵, 190971⁶, 190991⁷, 191001⁸, 191731⁹, 191741¹⁰, 191751¹¹, 191771¹², 201721¹³), Амбулаторийн өндөр өртөгт оношилгоо шинжилгээ (300040¹⁴) зэрэг байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудаас сонгон шалгаруулалтын хүсэлтийг шаардлага хангасан тухай бүрд нь хүлээн авч шийдвэрлэж, гэрээнд нэмэлт өөрчлөлтийг оруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдал хангагдах боломжийг бүрдүүлдэг болох зохицуулалт хийх шаардлагатай байна.

Б.1.5 Эрүүл мэндийн даатгалын гэрээг хугацаанд нь дүгнэдэггүй, гэрээний эрх, үүрэг хангагдахгүй байна.

Анхан шатны сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд Эрүүл мэндийн тухай хуулийн 24¹⁵ дүгээр зүйлийн 24.6.10-т заасан өрх, сумын хэмжээнд үзүүлэх зарим тусламж үйлчилгээ, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1¹⁶, 9.1.2¹⁷, 9.1.9¹⁸, 9.1.13¹⁹-т заасан хүний эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд анагаах ухааны нотолгоонд суурилсан аргаар чанартай, аюулгүй, шуурхай үзүүлэх зорилгоор Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй гэрээ байгуулж ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтсээр дамжуулан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд даатгалын гэрээг 2021, 2022 онд байгуулж ажилласан ч 2022 оны гэрээг гэрээнд заасан хугацаанд дүгнэж ажиллаагүй (2023 оны 05 сарын 01-ний байдлаар дүгнээгүй).

Сумын 14 Эмийн эргэлтийн сан, хувийн хэвшлийн 10 эмийн сантай даатгалын гэрээг 2021 онд байгуулан жилийн эцэст гэрээг дүгнэсэн.

Эрүүл мэндийн төвүүдтэй 2021 онд байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг авч үзвэл 15 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 7 сум 90 хувьтай, 8 сум

¹ Арьсны эмгэгийн сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ

² Сэргээн засахын амбулаторийн тусламж, үйлчилгээ

³ Сэргээн засахын өдрийн эмчилгээ

⁴ Эх барих эмэгтэйчүүдийн сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ

⁵ Сэтгэц идэвхт эм, бодисын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэг

⁶ Сэтгэл хөөрөх эмгэг

⁷ Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг

⁸ Бие хүний эмгэг, зуршилд ба импульсив эмгэгүүд

⁹ Сэтгэл цочирдох хоёр туйлт эмгэг

¹⁰ Шизоаффектив эмгэг

¹¹ Сэтгэл гутрах эмгэг

¹² Оюун хомсдох эмгэг

¹³ Архины шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэг

¹⁴ Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ

¹⁵ эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ

¹⁶ хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ;

¹⁷ амбулаторийн үзлэг, хяналт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ;

¹⁸ өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ;

¹⁹ Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.1, 24.6.2, 24.6.5-24.6.8, 24.6.10, 35¹.3-т заасан эмнэлгийн тусламж үйлчилгээ.

85 хувьтай үнэлэгдэж, гэрээнд заасан 1 иргэнээр тооцсон санхүүжилтийг авсан байна. /Хавсралт№4-өөс харна уу/

Өрхийн эрүүл мэндийн 2 төв нь тус бүр 85 хувьтай гэрээгээ дүгнүүлсэн байна.

Хувийн хэвшлийн болон Эмийн эргэлтийн сангуудтай байгуулсан гэрээг тус онд 18 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 11 ЭЭС, хувийн эмийн сан 80-89 хувь, 10 ЭЭС, хувийн эмийн сан 91-100 хувь, 1 буюу Эрдэнэдалай сумын Угтаалдалай хувийн эмийн сан нь 55 хувьтай үнэлэгдсэн байна. /Хавсралт№5-аас харна уу/

Харин 2022 онд 13 сумын Эм эргэлтийн сан, хувийн хэвшлийн 9 эмийн сантай даатгалын гэрээ байгуулж, 2021 оны гэрээний үүргээ биелүүлээгүй, гэрээ дүгнүүлээгүй Цагаандэлгэр сумын Эм эргэлтийн сан, Сайхан-Овоо сумын Хүслэн эмийн сантай гэрээ байгуулаагүй байна.

Эрүүл мэндийн даатгалын гэрээг байгуулахдаа гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлтийн талаар гэрээний оролцогч талуудын саналыг авдаггүй, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын ирүүлсэн гэрээний загвараар шууд гэрээг байгуулж, оролцогч талын санал, эрх ашгийг харгалзан үзэхгүй байна.

Эрүүл мэндийн газраас гэрээлэлтийн явцад хяналт тавих, өрх сумын эрүүл мэндийн төвүүдийг удирдлага арга зүйгээр хангах ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Гэрээг хугацаанд нь дүгнээгүйгээс сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн 1 иргэнээр тооцсон нормативт 20 хувийн санхүүжилт хугацаа хоцорсноос шалтгаалан цалин хөлс, хоол, шатахуун, эмийн зардлын өр үүсэх, үйл ажиллагаа тасалдах, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт удаашрах, хугацаанаас хамаарч зарим арга хэмжээ хэрэгжихгүй тасрах, дараагийн жилийн гэрээ байгуулагдахгүй тодорхойгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс байгуулах гэрээний шалгуур үзүүлэлтийг оролцогч талуудын саналуудыг тусгуулан, харилцан ашигтай байхад анхаарч, гэрээний оролцогч талуудын эрх, үүрэгт дүн шинжилгээ хийж, гэрээг хугацаанд нь дүгнэж ажиллах шаардлагатай байна.

Б.1.6 Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд үзүүлсэн тусламж үйлчилгээний төлбөрөө бүрэн авч чадахгүй байна.



Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон эрүүл мэндийн даатгалын санхүүжилт нь анхны дүнгээс хасагдаж, үзүүлсэн тусламж үйлчилгээний санхүүжилтээ бүрэн авахгүй байна.

Энэ нь тусламж үйлчилгээний чанар, үр дүнд нь үндэслэхгүй харин ажлын зохион байгуулалт, бүртгэл хөтлөлтийн алдаа, программын хөгжүүлэлт хангалтгүй байдлаас үүдсэн алдаанд нь үндэслэж байгаа нь үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо бий болгох үндсэн зорилгод нийцэхгүй байна.

Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн төвүүдийн үзүүлж буй тусламж үйлчилгээ нь ижил, ойролцоо байтал тогтоосон төлбөрийн үнэ тариф дээд шатлалын байгууллагуудтай харьцуулахад зөрүүтэй, зах зээл дээрх эм, бараа материалын үнийн өсөлт тогтмол нэмэгдэж байгаа ч тариф шинэчлэлдээгүй байна.

Хүн ам цөөн, Улаанбаатар хот болон Өвөрхангай, Говьсүмбэр аймгуудтай ойр орших Цагаандэлгэр, Баянжаргалан, Говь-Угтаал, Өндөршил, Сайхан-Овоо зэрэг сумдын эрүүл мэндийн төвүүд нь цалин хөлс, шатахуун, эмийн зардлын өр үүссэн, үүсэх нөхцөл бий болоод байгаа зэргээс харахад санхүүжилт төдийлөн үр нөлөөтэй бус байна. Мөн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн ам цөөн, аймгийн төвөөс алслагдсан суманд тооцож олгох аргачлалыг шинэчлэх, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12, 13 дугаар тогтоолуудад өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Говь-Угтаал, Баянжаргалан сумдын эрүүл мэндийн төвүүд 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 26.0–40.0 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан байна. Өр төлбөрөө барагдуулахын тулд Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж үйлчилгээний орлогоор эргэн төлөгдөх нөхцөлтэй урьдчилгаа санхүүжилт авсан байна. Дээрх сумдууд 2023 он гарсаар тусламж үйлчилгээний шийдвэрлэгдсэн санхүүжилтээс суутгуулж байгаа ч цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ын өр төлбөртэй байна. Мөн Цагаандэлгэр, Өндөршил сум, Боржигон мандал өрхийн ЭМТ-үүд 2023 оны байдлаар үйл ажиллагааны зардал, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн болон ХХОАТ-ын өглөгтэй ажиллаж байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны 11, 12 сарын нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 20 хувийг хугацаанд нь олголгүй 2023 оны 2 сард олгосон, 2022 оны гэрээг хугацаанд дүгнээгүй 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 1, 2, 3 дугаар сарын санхүүжилтийг шийдвэрлэж олгоогүй байна. Түүнчлэн 2023 оны гэрээ байгуулаагүй байгаа нь ЭМДЕГ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1.3, 16.1.5, 16.1.8-д заасан чиг үүргээ биелүүлээгүй, мөн хуулийн 13.1.1-д заасан гэрээ бүхий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрхийг хязгаарлаж байна.

Иймд даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн сард нь багтааж олгож байх шаардлагатай.


Бүлэг Б.2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд тодорхой ахиц дэвшил гаргаагүй байна.

Б.2.1. Эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажиллаагүй.

Эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлээгүй байна. ЭМГ-аас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, аймгийн Засаг даргаас ЭМС-тай байгуулсан гэрээнд тухайн чиглэлээр арга хэмжээ тусгагдаагүй байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил, арга хэмжээг төлөвлөж аймгийн Засаг даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Б.2.2 Цахим мэдээллийн систем найдвартай байдлыг хангаж чадахгүй байна.



Аймгийн нэгдсэн эмнэлэг www.eHealth.gov.mn, Уламжлалт анагаах ухааны төв, Мөнхдэлгэр, Элбэрэл буян хувийн эмнэлгүүд www.e-hospital.mn программыг, анхан шатлалын өрх, эрүүл мэндийн төвүүд болон Эм эргэлтийн сан, хувийн хэвшлийн эмийн сангууд нь 2021 оны 05 сараас www.health.gov.mn программыг, 2022 оны 08 сараас www.e-hospital.mn программыг ашиглаж ирсэн байна.

Эдгээр www.e-hospital.mn, www.health-info3.gov.mn, www.health.gov.mn, www.screening.gov.mn программууд нь хоорондоо мэдээлэл солилцох боломжгүй, программуудад нэг ижил төрлийн мэдээллийг давтан оруулдаг тул эмч нарт ажлын ачаалал бий болгож, үйлчлүүлэгчдийг хүлээлгэж бухимдуулдаг байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэст байгууллагууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн санхүүжилт нэхэмжилсэн материалаа программаар илгээхээс гадна цаасаар хэвлэж хүргүүлдэг байсан бол 2023 оны 04 дүгээр сараас бүх цаасан баримтыг хуулбарлан файлаар илгээж байгаа нь эмчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.

Мөн зарим тохиолдолд Хур системээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авагч иргэдийн мэдээлэл зөрүүтэй гарах алдаанаас үүдэж санхүүжилтүүд цахим хяналтаар мэдээлэл зөрүүтэй, үйлчилгээ авах эрхгүй шалтгаанаар хасагддаг байна.

Программын ашиглалтын талаар гомдол саналыг хүлээн авах эзэн тодорхойгүй, программ хөгжүүлэлтийн компани системд сайжруулалт хийдэггүй, алдааг засварладаггүй байна.

Иймээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, даатгалын үйл ажиллагаатай холбоотой ашиглагдаж байгаа дээрх программ хангамжуудын уялдаа холбоог сайжруулж, хоорондоо мэдээлэл солилцох боломжтой, ажлын ачааллыг бууруулах арга замыг судалж, эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх талаар Үндэсний аудитын газраар дамжуулан холбогдох байгууллагад санал хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Б.2.3 Эрүүл мэндийн даатгалын байгууллага иргэд, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Засаг даргын тамгын газрын дэргэдэх 7059-106 гомдол мэдээлэл хүлээн авах утас, сайт, ЗГХЭГ-ын дэргэдэх 11-11 төв болон Эрүүл мэндийн даатгалын хэлтэст 2021, 2022 онд иргэн, хуулийн этгээдээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилттэй холбоотой ирүүлсэн өргөдөл гомдол бүртгэгдээгүй байна.



Харин аудитын явцад аймгийн нэгдсэн эмнэлгүүд, Адаацаг, Дэлгэрцогт, Сайнцагаан, Говь-Угтаал, Баянжаргалан Эрдэнэдалай сумдын эрүүл мэндийн төв болон эм эргэлтийн сан, хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сан, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гүйцэтгэлийн аудитын уулзалт ярилцлага зохион байгуулахад Эрүүл мэндийн төв болон Эмийн эргэлтийн сангуудад ашиглаж байгаа программын талаарх алдаа, санхүүжилтийн хасагдлын талаар зөвлөмж ирүүлэх, зөвлөн туслах ажил зохион

байгуулдаггүй, шаардлагатай мэдээллээр хангах ажил дутмаг, салбар дундын хамтын ажиллагаа сул байгааг олноор илэрхийлж хандсан болно.

Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар даатгуулагчдад шаардлагатай мэдээллээр хангах ажлыг хэрхэн төлөвлөж хэрэгжүүлж байгаад дүн шинжилгээ хийж үзэхэд байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 арга хэмжээ төлөвлөж, тус арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай үнэлэгдсэн байна. Гэвч иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээ, мэдээлэл дутмаг, анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд үзүүлэх боломжгүй хязгаарлалттай оношийн бүлгээр тусламж үйлчилгээ авахыг хүсэх, дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх боломжтой талаарх тайлбар шалтгааныг хүлээж авдаггүй зэргээс үүссэн бухимдал гарч байна.

Нэгдсэн эмнэлгийн эмч нарт жор бичих эрх нь нээлттэй хэдий ч сум, өрхийн эмнэлгийн эмч нар руу явуулж жор бичүүлж байгаагаас шалтгаалж ажлын ачаалал нэмэхээс гадна, оношийн заалттай зөрчилдөж иргэдэд чирэгдэл үүсгэж байна.

Иргэд даатгуулагч нарт эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдээлэл хүргэх, эргэх холбоог бий болгох, сумдын нийгмийн даатгалын байцаагч нарын эрүүл мэндийн даатгалын орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих, эрүүл мэндийн даатгал төлөхийн ач холбогдлыг олон нийтэд таниулах сургалт мэдээллийг нийгмийн даатгалын хэлтэс, сумдын Засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Б.3. Хууль тогтоомжид заасан хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт, шинжилгээний үнэлгээ бодитой бүс байна.

Б.3.1. Хяналт, шинжилгээний үнэлгээ бодитой бүс байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2021, 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс гарган ирүүлсэн байна. Уг хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс үнэлгээний арга зүйн дагуу үнэлсэн байна. Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт № 3/

	ЗД-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөсөн арга хэмжээ	ХШҮХ-ийн үнэлгээ /хувиар/	
		2021	2022
2.1.3.2	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлэх.	100	100

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тусгагдсан зарим шаардлагатай ажлуудыг хэрэгжүүлээгүй, хөтөлбөр арга хэмжээний төлөвлөлт оновчгүй, гүйцэтгэл тодорхойгүй байхад аймгийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан дээрх заалтуудын хэрэгжилтийг хангалттай бүрэн хэрэгжсэн гэж үнэлсэн байгаа нь хяналт шинжилгээний үнэлгээ бодитой бус байгааг харуулж байна.

Цаашид үйл ажиллагааны хөтөлбөрийг үнэлж дүгнэх боломжтой байдлаар тодорхой төлөвлөж, хэрэгжилтийг нотлох баримт, хавсралт тооцоо судалгаатай тайлагнаж, бодит үр дүнг тооцож ажиллах нь зүйтэй.

Энэ нь аливаа хөтөлбөр арга хэмжээ, бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлж, тайлагнаж байгаа холбогдох байгууллага албан тушаалтны ажлын хариуцлагыг сулруулах, хэрэгжүүлэх арга хэмжээний ач холбогдлыг бууруулах, шаардлагатай ажлууд хийгдэхгүй орхигдох үр дагаврыг бий болгож байна.

Иймд үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийхдээ зөвхөн гүйцэтгэлийн тайлан, нотлох баримтаас гадна гүйцэтгэлийн тооцооллыг үнэлж хэрхэн судалгаа хийж үндэслэлтэй төлөвлөх, шалгуур үзүүлэлтийг оновчтой боловсруулах, тайлагнах талаар арга зүйн зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажиллах нь зүйтэй.

Б.3.2. Үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд хийсэн хяналтаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийгээгүй, эргэх холбоо тогтоох чиг үүрэг хангалтгүй байна.



Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12-р тогтоолоор батлагдсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-аар хяналт тавьж ажиллаж байна. Тус журмыг хэрэгжүүлсэн байдлыг хянаж үзэхэд Эрүүл мэндийн даатгалын газрын хүлээх эрх үүргийн 4.1.1.3-д заасан Чанар болон төлбөрийн хяналтын үр дүнд шинжилгээ хийж тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг ЭМБ-д өгөх, хамтарч ажиллах, эргэх холбоо тогтоох үүрэг хангалтгүй хэрэгжсэн байна.

Тухайлбал: Анхан шатны ЭМБ-ын чанар төлбөрийн хяналтын нэхэмжлэлтэй холбоотойгоор байгууллагуудад сар бүр зөвлөмжийг өгч эргэх холбоо тогтоож, хамтран ажиллах талаар тусгасан боловч нэхэмжилсэн санхүүжилтийн хасагдсан шалтгаан тодорхой бус, нийтлэг зөвлөмжийг 2021, 2022 онуудад нийт 5-6 удаа өгч ажилласан байна. Лавлагаа шатлалын ЭМБ-дад сар бүр албан бичгээр нэхэмжлэлийн хяналтын тайлбар мэдэгдэл хүргүүлдэг нь хэт ерөнхий агуулгатай байдаг тул үйлчилгээ үзүүлэгч байгууллага үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахад хүндрэл үүсдэг байна.

Иймд анхан шатны болон лавлагаа шатлалын ЭМБ-дад өгч байгаа зөвлөмжийг ойлгомжтой бөгөөд сайжруулах арга замыг тодорхой тусгаж тухай бүрд нь өгч, хэрэгжилтийг тооцон ажиллах шаардлагатай байна.



ЭМДЕГ-ын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд дотоод аудит хяналт, шинжилгээ үнэлгээ хийж байгаагүй.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 2022 оны 8 дугаар сарын 11-ны “журам шинэчлэн батлах тухай” тогтоолд нэхэмжлэлийн хяналт, цахим хяналт, нарийвчилсан хяналт, нэмэлт хяналт, эрүүл мэндийн байгууллагад газар дээр нь очиж хяналт хийх, эмнэл зүйн аудит чанарын үнэлгээ хийлгэх талаар тогтоол гарсан байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12-р тогтоолоор батлагдсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-аар Нэхэмжлэлийн хяналтыг ЭМБ-дад сар бүр хийж, нарийвчилсан хяналт, газар дээр нь очих хяналтыг өргөдөл, гомдол ирээгүй тул одоогоор тус хяналт шалгалт хийгдээгүй байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношийн бүлэг, эрэмбэлэлт нь бодит байдалтай нийцүүлэн тогтоогоогүйгээс иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хязгаарлагдаж байна.

1. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээ хөтөлбөр боловсруулах, түүний хэрэгжилт, үр дүнг тооцох, эрүүл мэндийн даатгал хариуцсан байгууллагуудыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, орлогын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан ажиллах шаардлагатай байна.
2. Эрүүл мэндийн даатгалын холбоотой зорилт, арга хэмжээг үндэсний болон салбарын бодлого хөтөлбөртэй уялдуулан боловсруулаагүй, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс эрүүл мэндийн даатгалын төлөвлөгөө хийгдээгүй, бодлого төлөвлөлт хангалтгүй байна.
3. Бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө суурь тооцоо судалгаа хийгээгүйгээс шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, санхүүжилтийн эх үүсвэр тодорхой бус, хэрэгжилтийг тайлагнаж байгаа боловч бодит үр дүнг тооцон үнэлээгүй байна.
4. Эрүүл мэндийн даатгалын орлого хураах, төвлөрүүлэх ажлыг хариуцсан Нийгмийн даатгалын хэлтэс нь сумдын байцаагч нарт орлогын төлөвлөгөөг 2020-2021 онд хуваарилж хүргээгүй, төлөвлөгөөний биелэлтийг тооцож дүгнээгүй байна.
5. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтсийн ажлын уялдаа холбоо хангалтгүй, Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс эрүүл мэндийн даатгалын хамрагдалтад тогтмол хяналт тавьдаггүй, иргэдэд эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах ажил хангалтгүй байна.

6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад сар улирлаар тогтмол өгч байх санхүүжилтийн хяналтаар гарсан хасагдлын тайлбар, тухайлсан зөвлөмжийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд өгч ажиллаагүйгээс санхүүжилтийн хасагдал ихээр гарч алдаа дутагдлаа залруулах боломжоор хангагдаагүй байна.
7. Сонгон шалгаруулалтын хүсэлтийг шаардлага хангасан тухай бүрд нь хүлээн авч шийдвэрлэдэггүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдал хангагдахгүй байна.
8. ЭМДХ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай гэрээ байгуулахдаа гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлтийн талаар гэрээний оролцогч талуудын саналыг авдаггүй, ЭМДЕГ-ын ирүүлсэн гэрээний загвараар шууд гэрээг байгуулж, оролцогч талын санал, эрх ашгийг харгалзан үзээгүй байна.
9. Одоогийн мөрдөж байгаа эрүүл мэндийн даатгалын тарифыг зах зээлийн үнэтэй уялдуулан жил бүр өөрчлөхгүй байгаатай холбоотой эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд санхүүжилтийн алдагдалд орж байна.
10. Аймгийн Эрүүл мэндийн газраас сумдын эрүүл мэндийн төвүүдийн дутагдалтай байгаа эмчийн судалгааг авч нэгтгэдэг ч хангалтыг нэмэгдүүлэх үр дүнтэй ажил хэрэгжүүлээгүй байна.
11. Эрүүл мэндийн даатгалын хэлтэст байгууллагууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн санхүүжилт хүссэн материалаа программаар илгээхээс гадна хэвлэж хүргүүлэх, скан хийж файлаар илгээж байгаа нь эмчийн ажлын ачааллыг улам нэмэгдүүлсэн байна.
12. Нэгдсэн эмнэлгийн эмч нарт жор бичих эрх нь нээлттэй хэдий ч сум, өрхийн эмнэлгийн эмч нар руу явуулж жор бичүүлж байгаагаас шалтгаалж ажлын ачаалал нэмэхээс гадна, оношийн заалттай зөрчилдөж иргэдэд чирэгдэл үүсгэж байна.
13. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилтийг олгохдоо Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 07, 12 дугаар тогтоолоор батлагдсан "Чанар, төлбөрийн хяналтын журам"-аар хянаж шийдвэрлэдэг ч оношийн хамааралтай бүлэгт холбогдолгүй, яаралтай тусламжийн эрэмбийг хязгаарласан, сумдад эмчийн дутагдал их байгаагаас ажлын ачаалал ихсэж бодит цагийн горимд амжиж мэдээллийг илгээгүйгээс санхүүжилт ихээр хасагдаж байна.
14. Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлээгүй байна.
15. Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа www.e-hospital.mn, www.h-info.gov.mn, www.health.gov.mn программууд нь хоорондоо мэдээлэл солилцох боломжгүй, программуудад нэг ижил төрлийн мэдээллийг давтан оруулдгаас эмчийн ажлын ачаалал бий болгож, үйлчлүүлэгчдийг бухимдуулж байна.
16. Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс анхан шатны болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад өгч байгаа зөвлөмжийг ойлгомжтой бөгөөд сайжруулах арга замыг тодорхой тусгаж тухай бүрд нь өгч, хэрэгжилтийг тооцон ажиллах шаардлагатай байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Эрүүл мэндийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг бодлогын баримт бичигт тусгахдаа тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоон, жил бүрийн хүрэх түвшин, хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, удирдлага арга зүйгээр хангаж, хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт хийн, үр дүнг тооцон ажиллах;
2. Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй жил бүр байгуулдаг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чанарын болон зөвлөмжийн мөрөөр гүйцэтгэлийн хяналт хийх, эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар тогтмол мэдээллээр хангах арга хэмжээг оновчтой төлөвлүүлэн, тусгуулан хэрэгжүүлэх;
3. Сумдын Засаг дарга нартай жил бүрийн хамтран ажиллах гэрээнд иргэдэд эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг таниулах сургалт мэдээллийг багийн Засаг дарга нараар дамжуулан хүргэх, сумын нийгмийн даатгалын байцаагчийн төлөвлөгөөг биелүүлэхэд хамтран ажиллах тухай заалтыг тусган, хэрэгжилтийг аймгийн хэмжээнд нэгтгэн танилцуулах;
4. Сумдын эрүүл мэндийн төвүүдэд дутагдалтай байгаа эмчийн орон тоог бүрдүүлэх, аймгийн хүний нөөцийг дэмжих хөтөлбөрөөр болон бусад боломжит эх үүсвэрээр эмч нарыг бэлтгэх, орон нутагт ажиллаж, амьдрах нөхцөл боломжоор хангах бодлогыг хэрэгжүүлэх;

Эрүүл мэндийн газарт:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс байгуулах гэрээний шалгуур үзүүлэлтийг оролцогч талуудын саналыг тусгуулан, харилцан ашигтай байхад анхаарч, удирдлага арга зүйгээр хангах, гэрээний оролцогч талуудын эрх, үүрэгт дүн шинжилгээ хийж ажиллах;
2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил, арга хэмжээг төлөвлөж, аймгийн Засаг даргатай байгуулах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайдтай аймгийн Засаг даргаас байгуулах гэрээнд тусган хэрэгжүүлэх;

Нийгмийн даатгалын хэлтэст:

1. Сумдын нийгмийн даатгалын байцаагч нарт эрүүл мэндийн даатгалын орлогын төлөвлөгөөг хүн амын тоонд тулгуурлан бодитойгоор хуваарилан өгөх, төлөвлөгөөний гүйцэтгэлд сар бүр хяналт тавьж, ажиллах;

Эрүүл мэндийн даатгалын хэлтэст:

1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт дутуу орон тооны захиалгаа хүргүүлэн, хүний нөөцийг бүрдүүлэх;
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чанарын үнэлгээ хийх, зөвлөмжийн болон гомдол саналын мөрөөр гүйцэтгэлийн хяналт хэрэгжүүлэх хуваарь гарган баталж хэрэгжүүлэх;
3. Гүйцэтгэлийн хяналтын болон чанарын үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, зөрчлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан удирдах албан тушаалтанд хүргэх, хэрэгжүүлэх;

Сумдын эрүүл мэндийн төвүүдэд:

1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний үүргийн дагуу үзүүлсэн тусламж үйлчилгээний нэхэмжлэлийг бусад холбогдох материалын хамт хугацаанд нь чанартай бүрэн хүргүүлж, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зарцуулах.



Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

ҮАГ-аар дамжуулан холбогдох яамдад стандарт, дүрэм журам аргачлал боловсруулах, өөрчлөлт оруулах саналыг уламжилж байна.

Үндэслэл 1:

Нийгмийн даатгалын байцаагч нар иргэдийг И-баримтын системээр нэвтэрч даатгалаа төлөхийг зөвлөж төлүүлдэг ч сумын төрийн сангийн дансанд ордоггүй тул сумын мэдээнд ордоггүй, Нийгмийн даатгалын хэлтсээс сумдаар нь гаргаж өгдөггүйгээс орлогын гүйцэтгэлийг тооцох боломжгүйд хүргэж байна.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 2-р бүлгийн Б.1.1-р хэсгээс харна уу/

Санал 1:

Эрүүл мэндийн даатгалын хураамжийг И-баримтаар төлсөн тохиолдолд сумын төрийн сангийн дансанд төвлөрдөг байхаар зохицуулж, орлогын гүйцэтгэлийг тооцох боломжийг олгох.

Үндэслэл 2:

Яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээний голлох тохиолдолд дээд шатлалын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа онош дийлэнх тохиолддог, анхан шатанд тохирох онош, яаралтай болон түргэн тусламж, амбулаториор тусламж үйлчилгээг үзүүлэхэд шинж тэмдгийн онош тавьж эмчилдэг ч санхүүжилт нь хасагддаг байна. Анхан шат болон лавлагаа шатны эрүүл мэндийн төвүүдэд эмчлэгдэх боломжтой онош www.e-hospital.mn программын оношийн бүлэгтэй тохирохгүй байдал үүсдэгээс эмчилгээний зардлын дүнгээр алдагдал үүсдэг. *Жишээ нь: Яаралтай тусламж бол амь тэнссэн үед болон аюултай нөхцөлд хүний амь насыг аврахын тулд яаралтай авч хэрэгжүүлдэг арга хэмжээнүүд, өвчтөний биеийн байдлыг тогтворжуулж эмнэлгийн дараагийн тусламж авах бололцоог бүрдүүлэн хэвтүүлэн эмчилдэг байна. Хэвтүүлэн эмчлүүлсэн тарифт нь багтсан гэдэг тайлбараар 248 хүний 42.5 сая төгрөгийг хэвтэн давхардсан шалтгаанаар хассан. Энэ нь тохиолдол бүрийг санхүүжүүлнэ гэдэгтэй уялдахгүй байна.*

/Дэлгэрэнгүйг тайлангийн 2-р бүлгийн Б.1.2-р хэсгээс харна уу/

Санал 2:

Анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагуудад эмчлэх боломжтой эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношийн бүлгийг нэмэгдүүлэх, зарим шаардлагатай оношуудын шатлалыг бууруулж даатгуулагч орон нутагтаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлэх.

Үндэслэл:3

Оношийн хамааралтай бүлэгт холбогдолгүй, яаралтай тусламжийн эрэмбийг хязгаарласан, эмчийн дутагдалтайгаас ажлын ачаалал ихсэж бодит цагийн горимд хугацаандаа мэдээллийг оруулаагүйгээс эмчийн болон цахим хасагдлаар санхүүжилт ихээр хасагдаж байна. *Жишээ нь: Мэс заслын тусламж үйлчилгээний хувьд эмчийн үйлдлийн онош Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 01 дүгээр тогтоолд байхгүй учраас эмч өөрийн*

хийсэн үйлдлийн кодоо сонгодог учир оношийн бүлэгт хамааралгүй шалтгаанаар 48 хүний 28.2 сая төгрөг хасагдсан.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 2-р бүлгийн Б.1.2-р хэсгээс харна уу/

Санал:3

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт үр нөлөөтэй бус системийн хэмжээний бодлого шийдвэр, дүрэм журамд өөрчлөлт шинэчлэлт хийх зайлшгүй шаардлагатай байна. Мөн ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.4²⁰ -д заасан уян хатан байх, өөрчлөлттэй уялдах гэсэн зарчмаа зарим тусламж үйлчилгээний хяналтын хасагдлын алдааг агуулга, тусламж үйлчилгээний чанарт нөлөөлж буй байдалд үнэлэлт дүгнэлт хийж тодорхой хувиар бууруулж олгодог болох саналтай байна.

Үндэслэл:4

Сонгон шалгаруулалтыг 3 жилд нэг удаа зохион байгуулж, тус хугацаанд гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах зохицуулалт байхгүйгээс оношийн хамааралтай бүлгээр гэрээлж чадаагүй ч тусламж үйлчилгээг үзүүлэх шаардлага үүсдэг тул сонгон шалгаруулалтын хүсэлтийг шаардлага хангасан тухай бүрд нь хүлээн авч шийдвэрлэдэггүй. *Жишээ нь:Тусламж үйлчилгээний гэрээ хийгдээгүй шалтгаанаар 9 хүний 12.9 сая төгрөг, гэрээний тоон хязгаар хэтэрсэн шалтгаанаар 105 хүний 16.8 сая төгрөгийн тусламж үйлчилгээний нийт 29.7 сая төгрөгийн санхүүжилт хасагдсан. Нэг тусламж үйлчилгээ үзүүлэхэд эмнэлгийн бүх ажилчдын оролцоо байдаг тул тусламж үйлчилгээний санхүүжилтийг 100 хувь хасах нь гүйцэтгэлээр санхүүжих, менежмент сайтай ажиллах боломжгүй болгож байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн байгууллагуудын дунд сонгон шалгаруулалтын хугацаанд мэргэжлийн эмчгүй тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй болдог. Харин мэргэжлийн эмчээр хангагдсан үеэс эхлэн тусламж үйлчилгээнүүдээ явуулж эхэлдэг боловч эрүүл мэндийн хөгжлийн төвөөс шалтгаалан дараагийн эрүүл мэндийн даатгалын сонгон шалгаруулалтыг хүлээн тусламж үйлчилгээгээ огт санхүүжилтгүйгээр үргэлжлүүлдэг байна. Энэхүү шалтгааны улмаас 6.1 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.*

/Дэлгэрэнгүйг тайлангийн 2-р бүлгийн Б.1.4-р хэсгээс харна уу/

Санал 4:

Сонгон шалгаруулалтын хүсэлтийг шаардлага хангасан тухай бүрд нь хүлээн авч шийдвэрлэж, гэрээнд нэмэлт өөрчлөлтийг оруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдал хангагдах боломжийг бүрдүүлэх.

Үндэслэл 5:

Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн төвүүдийн үзүүлж буй тусламж үйлчилгээ нь ижил, ойролцоо байтал тогтоосон төлбөрийн үнэ тариф дээд шатлалын

байгууллагуудтай харьцуулахад ихэд зөрүүтэй, зах зээл дээрх эм, бараа материалын үнийн өсөлт тогтмол нэмэгдэж байгаа ч тариф шинэчлэгддэггүй байна.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 2-р бүлгийн Б.1.6-р хэсгээс харна уу/

Санал 5:

Эмийн болон хүнс, бараа материалын үнийн өсөлттэй уялдуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үнэ тарифыг тогтмол шинэчилдэг байх, ижил үйлчилгээ үзүүлдэг байтал тусламж үйлчилгээний тариф эрүүл мэндийн байгууллагын шатлалаараа ихэд зөрүүтэй байгаад анхаарч шийдвэрлэх.

Үндэслэл 6:

Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа www.e-hospital.mn, www.health-info3.gov.mn, www.health.gov.mn, www.screening.gov.mn программууд нь хоорондоо мэдээлэл солилцох боломжгүй, программуудад нэг ижил төрлийн мэдээллийг давтан оруулдаг тул эмч нарт ажлын ачаалал бий болгож, үйлчлүүлэгчдийг хүлээлгэж бухимдуулдаг байна. Мөн www.e-hospital.mn программыг 2022 оны 07 дугаар сараас анх нэвтрүүлэхдээ сургалт зохион байгуулаагүйгээс шалтгаалж цахим хасалтаар 2022 онд нийт 515.8 сая төгрөгийн санхүүжилт хасагдсан.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 2-р бүлгийн Б.2.2-р хэсгээс харна уу/

Санал 6:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, даатгалын үйл ажиллагаатай холбоотой ашиглагдаж байгаа программ хангамжуудын уялдаа холбоог сайжруулж, хоорондоо мэдээлэл солилцох боломжтой, ажлын ачааллыг бууруулах арга замыг судалж, эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх;




Шалгагдагч байгууллагын санал, тайлбар


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын ордон,
7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас/факс: 70592353 Цахим шуудан: info@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2023.05.18 № 08/720
танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д гүйцэтгэлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.
Тайлангийн төсөлд санал тайлбар байхгүй болно.

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Н.ЭРДЭНЭ-ОЧИР

483143470



“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй холбогдох хэлтсийн дарга нар, мэргэжилтэнгүүдийн хамт уншиж танилцлаа.

Тайлангийн төслийн Б.2.1 дэх заалтанд эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн нэмэлт урьдчилан сэргийлэх, үзлэг оношилгоог зохион байгуулсан тоон болон үндсэн мэдээллийг хүргүүлсэн.

Иймд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах, үр дүнтэй арга хэмжээг төлөвлөөгүй гэсэн дүгнэлттэй санал нийлэхгүй байна.



Дундговь аймгийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн тайлбарт хариу өгөх Аудитын газрын тайлбар

Тайлбар 1	Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээнд “Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу эмзэг бүлгийн иргэдийг бүрэн хамруулах, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллах, эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааг тогтмол хийж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлж ажиллана” гэсэн заалт тусгасан боловч тус арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх, ямар үйл ажиллагаа зохион байгуулах талаар төлөвлөөгүй, аймгийн бодлогын баримт бичигт тусгаагүй байгаа учраас тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.
-----------	---



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ
МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

48090, Дундговь аймаг, Мандалговь сум
Утас/Факс: (976) 7059-3363, И-мэйл: dundgovi@emd.gov.mn
Вэбсайт: www.emd.gov.mn

2023.05.19 № 21/26
танай 2013.05.17-ны № 1/56 -Т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Р.МӨНХТОГТОХ ТАНАА

Танай байгууллагын “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д гүйцэтгэлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

Санал тайлбаргүй болно.

ДАРГА С.ДОЛГОРСҮРЭН



“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТ, ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/Хавсралт 1/
/сая.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020						2021						2022					
		Хамрагдвал зохих хүний тоо	Хамрагдсан хүний тоо	Хамралтын хувь	Орлогын төлөвлөлт /Сая төгрөг/	Шимтгэлийн орлого /Сая төгрөг/	Орлогын төлөвлөгөөний	Хамрагдвал зохих хүний тоо	Хамрагдсан хүний тоо	Хамралтын хувь	Орлогын төлөвлөлт /Сая төгрөг/	Шимтгэлийн орлого /Сая төгрөг/	Орлогын төлөвлөгөөний	Хамрагдвал зохих хүний	Хамрагдсан хүний тоо	Хамралтын хувь	Орлогын төлөвлөлт /Сая төгрөг/	Шимтгэлийн орлого /Сая төгрөг/	Орлогын төлөвлөгөөний
1	Төсөвт болон ААНБ-ын ажилтан	-	5,845	100	2,299.8	2,355.0		-	4,023	100	2,176.4	2,308.8		-	5,079	100	2,800.0	2,907.3	
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	2,800	1,245	44.5	392.6	58.0	67,5	2,800	763	27.3	392.6	56.0	71,5	2,520	822	32.6	210.4	54.7	38,6
3	Малчин	7,600	3,519	46.3		182.5		7,600	2,776	36.5		201.6		6,000	3,007	50.1	501.3	228.5	
4	Оюутан, суралцагч	850	528	62.1		24.4		850	251	29.5		23.2		900	242	26.9	76.5	21.0	
	Дүн	11,250	11,137		2,692.4	2,619.9	0	11,250	7,813		2,569.0	2,589.6		9,420	9,150		3,588.2	3,211.5	
5	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	-	-	-		-			-	-		-		-	-	-		-	
6	0-18 насны хүүхэд	-	16,771	100					16,908	100				-	17,983	100			
7	Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн	-	8,544	100					9,991	100				-	9,650	100			
8	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн	-	4,467	100		-			5,967	100		-		-	3,671	100		-	
9	Хүүхдээ асарч буй эх/эцэг	-	1,612	100					1,138	100				-	1,403	100			
10	Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	-	-	100					-	100				-	-	100			
11	Ял эдэлж байгаа ялтан	-	-						4					-	6				
12	Бусад (хуулийн 6.1.12 дахь заалтын даатгуулагч)	-	-	-		-			-	-		-		-		-		-	
	НИЙТ	11,250	42,531	-	2,692.4	2,619.9	-	11,250.0	41,821.0	-	2,569.0	2,589.6	-	9,420.0	41,863.0	-	3,588.2	3,211.5	

СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН 2021 ОНД ЭМДС-ГААС ХҮЛЭЭН АВСАН НИЙТ САНХҮҮЖИЛТ

/Аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь ЭМДЕГ-т гаргадаг мэдээ судалгаанаас/

/Хавсралт 2/
/сая.төгрөгөөр/

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Өрхийн эмнэлгийн ТҮ -ний дүн						УСЭИОШ-ний дүн						Элэг бүтэн В,С илрүүлэг			
		Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгохоор тооцсон		Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгохоор тооцсон		Нэхэмжилсэн		Олгохоор тооцсон	
		Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн
1	Адаацаг СЭМТ	650	21,099.8	32	1,513.5	618	19,586.4		-				-				
2	Баянжаргалан СЭМТ	370	11,452.6	31	1,330.6	339	10,122.0		-				-				
3	Гурвансайхан СЭМТ	592	10,611.5	58	1,164.6	534	9,446.9	5	100.0	-		5	100.0				
4	Дэлгэрхангай СЭМТ	207	7,709.8	34	1,199.8	173	6,510.0	3	60.0	-		3	60.0				
5	Дэлгэрцогт СЭМТ	124	6,320.6	14	950.9	110	5,369.7		-				-				
6	Дэрэн СЭМТ	268	10,843.4	13	1,220.5	255	9,622.9		-				-				
7	Луус сум СЭМТ	714	22,464.8	20	769.3	694	21,695.6	67	3,080.0	-		67	3,080.0				
13	Өндөршил СЭМТ	338	12,950.6	103	2,604.8	235	10,345.8		-				-				
8	Сайнцагаан СЭМТ	1,514	33,617.1	217	3,412.1	1,297	30,205.0		-				-	3	10.5	3	10.5
9	Сайхан-Овоо СЭМТ	130	9,187.5	7	497.1	123	8,690.4		-				-				
10	Хулд СЭМТ	527	17,721.0	105	3,003.6	422	14,717.4	155	3,400.0	1	20	154	3,380.0				
11	Цагаандэлгэр СЭМТ	219	11,409.0	53	1,981.8	166	9,427.2		-				-				
12	Өлзийт СЭМТ	409	9,807.5	23	933.6	386	8,873.9		-				-	2	7.0	2	7.0
14	Говь-Угтаал СЭМТ	82	10,333.7	25	3,887.6	107	6,446.1		-				-				
15	Эрдэнэдалай СЭМТ	212	14,936.6	39	4,511.1	173	10,425.5	53	1,059.0	-		53	1,059.0				
16	Боржигон мандал ӨЭМТ	395	8,653.1	91	1,524.0	304	7,129.1		-				-				
17	Өлзийт мандал ӨЭМТ	835	16,404.2	138	373.9	697	16,030.3	24	470.0	-		24	470.0	75	262.5	75	262.5

/үргэлжлэл/

/сая.төгрөгөөр

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Ковид хэвтэн						Ковид өрх						Ковид вакцин			
		Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгохоор тооцсон		Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгохоор тооцсон		Нэхэмжилсэн		Олгохоор тооцсон	
		Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн
1	Адаацаг СЭМТ	424	405,900.0	3	2,940.0	421	402,960.0	408	65,280.0	7	1,120.0	401	64,160.0	2,998	14,990.0	2,998	14,990.0
2	Баянжаргалан СЭМТ	151	148,900.0	3	2,940.0	148	145,960.0	138	22,080.0	10	1,600.0	128	20,480.0	2,354	11,770.0	2,354	11,770.0
3	Гурвансайхан СЭМТ	97	94,690.0	14	12,840.0	83	81,850.0	320	51,200.0	65	10,400.0	255	40,800.0	2,612	13,060.0	2,612	13,060.0
4	Дэлгэрхангай СЭМТ	255	232,350.0	6	5,750.0	249	226,600.0	131	20,960.0	21	3,360.0	110	17,600.0	2,551	12,755.0	2,551	12,755.0
5	Дэлгэрцогт СЭМТ	269	263,620.0	8	7,920.0	261	255,700.0	68	10,880.0	1	160.0	67	10,720.0	1,882	9,410.0	1,882	9,410.0
6	Дэрэн СЭМТ	233	222,620.0	2	1,960.0	231	220,660.0	81	12,960.0	3	480.0	78	12,480.0	2,212	11,060.0	2,212	11,060.0
7	Луус сум СЭМТ	842	284,480.0	131	4,900.0	711	279,580.0	59	9,440.0	1	160.0	58	9,280.0	1,891	9,455.0	1,891	9,455.0
13	Өндөршил СЭМТ	199	151,360.0	48	2,940.0	151	148,420.0	113	18,080.0	16	2,560.0	97	15,520.0	2,472	12,360.0	2,472	12,360.0
8	Сайнцагаан СЭМТ		-		-			1,528	243,760.0	716	113,880.0	812	129,880.0	10,765	53,825.0	10,765	53,825.0
9	Сайхан-Овоо СЭМТ	219	216,910.0	10	12,740.0	209	204,170.0		-		-		-	1,996	9,980.0	1,996	9,980.0
10	Хулд СЭМТ	379	367,710.0	7	5,360.0	372	362,350.0		-		-		-	2,228	11,140.0	2,228	11,140.0
11	Цагаандэлгэр СЭМТ	924	157,000.0	764	980.0	160	156,020.0	1	70,00	-	-	1	70,00	1,908	9,540.0	1,908	9,540.0
12	Өлзийт СЭМТ	244	233,950.0	2	-	242	233,950.0	209	33,440.0	38	6,010.0	171	27,430.0	2,349	11,745.0	2,349	11,745.0
14	Говь-угтаал СЭМТ	138	135,240.0	7	6,290.0	131	128,950.0	119	19,040.0	4	640.0	115	18,400.0	2,643	13,215.0	2,643	13,215.0
15	Эрдэнэдалай СЭМТ	11,388	434,210.0	10,936	4,900.0	452	429,310.0	464	74,240.0	409	65,440.0	55	8,800.0	5,845	29,225.0	5,845	29,225.0
16	Боржигон мандал ӨЭМТ		-		-		-	1,582	253,120.0	707	113,120.0	875	140,000.0	5,803	29,015.0	5,803	29,015.0
17	Өлзийт мандал ӨЭМТ		-		-		-	2,398	383,590.0	661	105,690.0	1,737	277,900.0	6,782	33,910.0	6,782	33,910.0

/үргэлжлэл/

№	Сумын эрүүл мэндийн төв	Нэг иргэн санхүүжилт		СЭМТ						Анхан шат							
				Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгосон санхүүжилт		Нэхэмжилсэн		Хасагдсан		Тооцсон		Олгосон санхүүжилт	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Адаацаг СЭМТ	2,122	350,206.0	658	22,402.0	101	3,621.0	157	17,982.0	103	186,602.0	3	321.0		5,793.0	100	180,488.0
2	Баянжаргалан СЭМТ	985	207,985.0	439	13,028.0	131	3,059.0	308	9,969.0	84	128,921.0	5	826.0		5,973.0	79	122,122.0
3	Гурвансайхан СЭМТ	1,606	258,581.0	495	10,754.0	136	3,556.0	359	6,278.0	57	99,406.0		0.0		6,846.0	57	92,560.0
4	Дэлгэрхангай СЭМТ	1,752	309,762.0	432	16,129.0	108	3,562.0	324	12,567.0	57	136,098.0	2	480.0		1,082.0	55	134,536.0
5	Дэлгэрцогт СЭМТ	1,238	222,348.0	15	403.0	2	138.0	4	264.0		119,449.0		0.0		0.0		119,449.0
6	Дэрэн СЭМТ	1,618	281,565.0	115	7,009.0	33	1,879.0	82	5,030.0	24	125,288.0	1	230.0		520.0	24	124,538.0
7	Луус сум СЭМТ	1,429	243,750.0	653	24,069.0	161	4,962.0	492	18,407.0	47	129,859.0	9	2,522.0		3,609.0	38	123,728.0
8	Сайнцагаан СЭМТ	4,000	374,382.0	1,004	27,487.0	250	6,110.0	754	21,317.0	20	51,175.0		0.0		0.0	20	51,175.0
9	Сайхан-Овоо СЭМТ	1,600	284,358.0	18	1,591.0	10	972.0	8	619.0	22	76,714.0	3	750.0		787.0	19	75,177.0
10	Хулд СЭМТ	1,800	316,182.0	302	12,344.0	102	2,731.0	200	9,612.0	7	129,218.0	1	250.0		1,731.0	6	127,237.0
11	Цагаандэлгэр СЭМТ	799	176,020.0	141	7,166.0	52	2,311.0	89	4,855.0	6	99,124.0		0.0		0.0	6	99,124.0
12	Өлзийт СЭМТ	1,804	314,030.0	223	8,954.0	122	4,917.0	101	4,037.0	28	95,142.0	2	480.0		7,138.0	26	87,524.0
13	Өндөршил СЭМТ	1,081	217,299.0	435	16,616.0	168	5,488.0	267	11,128.0	54	146,717.0	12	3,638.0		14,005.0	42	129,074.0
14	Говь-Угтаал СЭМТ	1,166	278,355.0	200	5,055.0	44	479.0	156	4,477.0	46	147,898.0	14	987.0		5,374.0	32	141,537.0
15	Эрдэнэдалай СЭМТ	4,454	579,996.0	451	15,074.0	123	4,463.0	328	10,611.0	42	281,320	13	1,197.0		10,724.0	29	269,399.0

/үргэлжлэл/

/сая.төгрөгөөр/

№	Сумын эрүүл мэндийн төв	Ковид 19 вакцин санхүүжилт		Ковид өрх						ЭМДС-с авсан нийт санхүүжилт
				Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгосон санхүүжилт		
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Мөнгөн дүн
1	Адаацаг СЭМТ	429	2,145.0	101	16,160.0	18	320.0	85	12,640.0	563,461.0
2	Баянжаргалан СЭМТ	183	915.0	17	2,720.0	16	2,470.0	0	0.0	340,990.0
3	Гурвансайхан СЭМТ	121	605.0	125	20,000.0	12	800.0	119	17,920.0	375,944.0
4	Дэлгэрхангай СЭМТ	267	1,335.0	12	1,920.0		0.0	12	1,920.0	460,120.0
5	Дэлгэрцогт СЭМТ	239	1,195.0	20	3,200.0	1	160.0	19	3,040.0	346,296.0
6	Дэрэн СЭМТ	194	970.0	36	5,760.0	34	5,440.0	0	0.0	412,103.0
7	Луус сум СЭМТ	164	820.0	46	7,360.0	1	160.0	43	7,200.0	393,905.0
8	Сайнцагаан СЭМТ	755	3,775.0	1,173	187,680.0	472	57,120.0	265	42,400.0	493,049.0
9	Сайхан-Овоо СЭМТ	131	655.0	0	0.0		0.0	0	0.0	360,809.0
10	Хулд СЭМТ	149	745.0	67	10,720.0	42	6,720.0	20	3,200.0	456,977.0
11	Цагаандэлгэр СЭМТ	57	285.0	0	6,720.0		0.0	42	6,720.0	287,005.0
12	Өлзийт СЭМТ	166	830.0	151	24,160.0	10	640.0	37	20,480.0	426,902.0
13	Өндөршил СЭМТ	121	605.0	66	10,560.0	27	4,320.0	37	5,920.0	364,026.0
14	Говь-угтаал СЭМТ	185	925.0	66	10,560.0	3	480.0	63	10,080.0	435,374.0
15	Эрдэнэдалай СЭМТ	419	2,095.0	128	20,480.0	70	11,200.0	47	7,520.0	869,620.0
	Нийт дүн	3,580	17,900.0	2,008	328,000.0	706	89,830.0	789	139,040.0	6,586,580.0

Аймгийн эрүүл мэндийн салбарын ажилчдын хүний нөөцийн судалгаа

/Хавсралт 3/

№	Сумдын нэр	Стандартын дагуу ажиллалал зохих											Одоо ажиллаж байгаа														Дутагдалтай байгаа											
		Их эмч	Багийн их эмч	Статистик	НЭМ	Бага эмч	Багийн бага эмч	Сувилагч	Эх баригч	Лаборант	Эм зүйч	Бусад	Бүгд	Их эмч	Багийн их эмч	Статистик	НЭМ	Бага эмч	Багийн бага эмч	Сувилагч	Эх баригч	Лаборант	Эм зүйч	Эм найруулагч	Рентген техникч	бусад	Бүгд	Их эмч	Багийн их эмч	Статистик	НЭМ	Сувилагч	Эх баригч	Лаборант	бусад	Бүгд	Хувь	
1	ЭМГ	1 2		1						2	16	31	1 0				1						2			16	29	2								2	89	
2	Нэгдсэн эмнэлэг	6 9		1		7		69	8	1 0	2	62	228	6 7		1		7		69	8	1 0	2	1	2	59	22 6	2									2	99
3	Адаацаг	1	3	1	1			5	1	1		6	19	1	3	1	1			5		1				7	19								-	10 0		
4	Цагаандэлгэр	1	3	1	1			5	1	1		6	19	1		1	1			5	1					5	14		3					1	1	5	74	
5	Гурвансайхан	1	3	1	1		1	5	1	1		7	21	1	2	1			1	4	1	1				5	16	1	1						1	5	76	
6	Дэлгэрцогт	1	3	1	1		1	5	1	1		7	21	1					1	3	1					9	15		3	1		2				6	86	
7	Луус	1	4	1	1			5	1	1		7	21	1	2	1	1			5	1	1				6	18		2						1	3	85	
8	Эрдэнэдалай	1	8	2	1		4	7	2	1		13	39	1	6	1	1	1	4	7	1	1		1		13	37		2							2	95	
9	Өлзийт	1	4	1	1		2	5	1	1		7	23	1	1	1			2	5	1					9	20		2					1		3	87	
10	Дэрэн	1	3	1	1			5	1	1		7	20	1	3	1				5	1	1				7	19					1				1	95	
11	Өндөршил	1	3	1	1			5	1	1		7	20	1	3	1				4	1	1				6	17					1	1			1	3	85
12	Говь-Угтаал	1	5	1	1			5	1	1		10	25	1	1	1				5	1	1				8	18		3		1					2	7	76
13	Хулд	1	4	1	1			5	1	1		7	21	1	1	1				5	1	1				7	17		3		1					4	81	
14	Баянжаргалан	1	2	1	1			5	1	1		9	21	1		1	1			4	1	1				9	18		2				1			3	91	
15	Сайхан-Овоо	1	4	1	1			5	1	1		8	22	1	2	1	1	2		1		1				8	17						4	1			5	80
16	Дэлгэрхангай	1	3	1	1	2		5	1	1		6	21	1	3	1	1	2		4		1				6	19						1	1			2	91
17	Сайнцагаан	1	3	1	1	2	2	2		1		5	18	1	2	1	1	2	2	2		1				4	16		1						1	2	89	
18	УАУНЭ	6		1	1	3		1				6	18	6		1	1	3		1						6	18									0	10 0	
19	Боржгон мандал	1	1	1	1			2				6	12	1	1	1	1			2						6	12									0	10 0	
20	Өлзийт мандал	1	3	1		1		3				2	11	1	3	1		1		3						2	11									0	10 0	
21	Зоонозын төв	3								1		6	10	2								1				5	8	1							1	2	80	

Нийт	107	59	21	17	15	10	149	23	26	4	210	641	102	33	18	10	19	10	139	19	23	4	2	2	203	584	6	22	1	4	10	3	2	8	57	92
Хангалт													95	62	86	53	100	100	92	83	88	100	100	100	99		5	38	14	47	8	17	12	100		

СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН ГЭРЭЭ ДҮГНЭСЭН БАЙДАЛ

/Хавсралт 4/

№	Байгууллагын нэр	2021			2022		
		Гэрээ байгуулсан эсэх	Гэрээ дүгнэсэн эсэх	Үнэлгээний хувь	Гэрээ байгуулсан эсэх	Гэрээ дүгнэсэн эсэх	Үнэлгээний хувь
1	Адаацаг СЭМТ	Тийм	Тийм	90	Тийм	Үгүй	-
2	Баянжаргалан СЭМТ	Тийм	Тийм	85	Тийм	Үгүй	-
3	Гурвансайхан СЭМТ	Тийм	Тийм	90	Тийм	Үгүй	-
4	Дэлгэрхангай СЭМТ	Тийм	Тийм	85	Тийм	Үгүй	-
5	Дэлгэрцогт СЭМТ	Тийм	Тийм	85	Тийм	Үгүй	-
6	Дэрэн СЭМТ	Тийм	Тийм	85	Тийм	Үгүй	-
7	Луус СЭМТ	Тийм	Тийм	90	Тийм	Үгүй	-
8	Өндөршил СЭМТ	Тийм	Тийм	90	Тийм	Үгүй	-
9	Сайнцагаан СЭМТ	Тийм	Тийм	90	Тийм	Үгүй	-
10	Сайхан-Овоо СЭМТ	Тийм	Тийм	85	Тийм	Үгүй	-
11	Хулд СЭМТ	Тийм	Тийм	85	Тийм	Үгүй	-
12	Цагаандэлгэр СЭМТ	Тийм	Тийм	85	Тийм	Үгүй	-
13	Өлзийт СЭМТ	Тийм	Тийм	90	Тийм	Үгүй	-
14	Говь-Угтаал СЭМТ	Тийм	Тийм	85	Тийм	Үгүй	-
15	Эрдэнэдалай СЭМТ	Тийм	Тийм	90	Тийм	Үгүй	-
16	Өлзийт мандал ӨЭМТ	Тийм	Тийм	85	Тийм	Үгүй	-
17	Боржигон мандал ӨЭМТ	Тийм	Тийм	85	Тийм	Үгүй	-

/Хавсралт 5/

ЭМИЙН САНГУУДЫН ГЭРЭЭ ДҮГНЭСЭН БАЙДАЛ

№	Байгууллагын нэр	2021			2022		
		Гэрээ байгуулсан эсэх	Гэрээ дүгнэсэн эсэх	Үнэлгээний хувь	Гэрээ байгуулсан эсэх	Гэрээ дүгнэсэн эсэх	Үнэлгээний хувь
1	Адаацаг ЭЭС	Тийм	Тийм	87	Тийм	Тийм	70
2	Баянжаргалан ЭЭС	Тийм	Тийм	85	Тийм	Тийм	60
3	Гурвансайхан ЭЭС	Тийм	Тийм	98	Тийм	Тийм	65
4	Дэлгэрхангай ЭЭС	Тийм	Тийм	82	Тийм	Тийм	70
5	Дэлгэрцогт ЭЭС	Тийм	Тийм	84	Тийм	Тийм	65
6	Дэрэн ЭЭС	Тийм	Тийм	84	Тийм	Тийм	65
7	Луус ЭЭС	Тийм	Тийм	94	Тийм	Тийм	65
8	Өндөршил ЭЭС	Тийм	Тийм	84	Тийм	Тийм	75
9	Сайхан-Овоо ЭЭС	Тийм	Тийм	89	Тийм	Тийм	65
10	Хулд ЭЭС	Тийм	Тийм	84	Тийм	Үгүй	
11	Цагаандэлгэр ЭЭС	Тийм	Тийм		Үгүй	Үгүй	
12	Өлзийт ЭЭС	Тийм	Тийм	89	Тийм	Тийм	65
13	Говь-Угтаал ЭЭС	Тийм	Тийм	94	Тийм	Тийм	65
14	Эрдэнэдалай ЭЭС	Тийм	Тийм	89	Тийм	Тийм	70
15	Дундговь эм хангамж /МЭИК/	Тийм	Тийм	98	Тийм	Тийм	95
16	МНЧ эмийн сан	Тийм	Тийм	100	Тийм	Тийм	95
17	Эдмонс фарм эмийн сан	Тийм	Тийм	96	Тийм	Тийм	95
18	Буяндэлгэр эмийн сан	Тийм	Тийм	94	Тийм	Тийм	80
19	Ар-Үр эмийн сан	Тийм	Тийм	94	Тийм	Тийм	65
20	Монос Дундговь эмийн сан	Тийм	Тийм	92	Тийм	Тийм	90
21	Мишээл эмийн сан	Тийм	Тийм	80	Тийм	Тийм	65
22	Хүслэн эмийн сан /Сайхан-Овоо/	Тийм	Тийм		Үгүй	Үгүй	
23	Цогт эмийн сан /Эрдэнэдалай/	Тийм	Тийм	91	Тийм	Тийм	75
24	Угтаалдалай эмийн сан /Эрдэнэдалай/	Тийм	Тийм	55	Тийм	Үгүй	

